



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, 13/1, Утас: 26-63-09, Факс: 32-99-33
E-mail: info@cd.gov.mn, http://www.cd.gov.mn/

2016. 01. 08 № 04/74

танай _____-ны № _____-т

Судалгаа ирүүлэх тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор Хууль сахиулахын их сургуулийн харьяа Ахлагчийн сургуультай хамтран "Харуул хамгаалалтын албаны ажилтан" бэлтгэх мэргэжлийн сургалтыг 2016 оны 03 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөж байна.

Иймд тус сургалтад хамрагдан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шинээр ажилд орох хүсэлтэй, тавигдах шаардлага хангасан иргэдийн бүрдүүлвэл зохих материалыг 2016 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор Албаны сургалт, дадлагын хэлтэст ирүүлнэ үү.

Эрэгтэй:


- ШШГБ-д ажиллахыг сайн дураар хүссэн, 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн;
- Ял шийтгэл эдэлж байгаагүй;
- 35 хүртэлх настай;
- Бие бялдрын зөв хөгжилтэй, 170 см-ээс доошгүй өндөртэй;
- Биеийн ил гарах хэсэгт шивээсгүй, чих цоолоогүй;
- Цэргийн жинхэнэ алба хаасан /1990 оны 05 сарын 06-нд төрсөн буюу түүнээс хойш төрсөн иргэдэд хамаарна/.

Эмэгтэй:

- Ял шийтгэл эдэлж байгаагүй эмч, эмнэлгийн мэргэжилтэй иргэдийг бүртгэлд хамруулна.

Сургалтад хамрагдах хүсэлтэй иргэдийн судалгаа, бүрдүүлвэл зохих материалын жагсаалтыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 01 хуудастай.

АЛБАНЫ СУРГАЛТ, ДАДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА,
ХУРАНДАА  Д.МӨНХСАЙХАН

My doc /A-4 tool/-2в О.Б

0001757

"ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН АЛБАНЫ АЖИЛТАН БЭЛТГЭХ"
СУРГАЛТАД ХАМРАГДАХ ХҮСЭЛТЭЙ ИРГЭДИЙН
БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Нэг. Бүрдүүлэх материал:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл /өөрийн гараар бичсэн/;
- Төрийн алба хаагчийн анкет /маягт 1/;
- Цахим үнэмлэх, боловсролын үнэмлэх, диплом, эрүүл мэндийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр, цэргийн үүрэгтний үнэмлэх, төрсний гэрчилгээ богино хэмжээний сургалтад хамрагдаж байсан бол сургалтын сертификатыг тус тус нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- Гурван үеийн түүх намтар;
- Цээж зураг /3х4, 4х6 хэмжээтэй зураг тус тус 2 хувь/;
- Оршин суугаа баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;
- Урьд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт /цэргийн байгууллагад ажиллаж байсан бол албан тушаалын цолны архивын лавлагаа/;
- Эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл.

Хоёр. Судалгаа:

- Эцэг, эх, өөрийн нэр;
- Нас, хүйс;
- Регистрийн дугаар;
- Төгссөн сургууль;
- Боловсрол;
- Мэргэжил;
- Цэргийн алба хаасан эсэх;
- Урьд өмнө ажиллаж байсан эсэх;
- Богино хугацааны сургалтад хамрагдаж байсан эсэх;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад гэр бүл, төрөл садангийн холбоотой хүн ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа эсэх;
- Ам бүл, гэрийн хаяг.

АЛБАНЫ СУРГАЛТ, ДАДЛАГЫН
ХЭЛТЭС